



УЛААНБААТАР
хотын Ардын Депутатуудын
хурлын Гүйцэтгэх Захиргааны
ТОГТООЛ

1969 оны 4-р сарын 10 ны өдөр

Дугаар 123.

Улаанбаатар хот

1980 оны 140
ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ.

Улаанбаатар хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргаанаас
ТОГТООХ нь:

Улаанбаатар хотын улс, хоршоолол, олон нийтийн байгуул-
лагуудын орон сууцны байрны зөвлөлийн дүрмийг баталсугай.

/дүрмийг хавсаргав/.

УЛААНБААТАР ХОТЫН АДХ ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ДАРГА *[Signature]* Д.ЦЭДЭВ
УЛААНБААТАР ХОТЫН АДХ ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА *[Signature]* Д.ДАМДИНСҮЭЭН

Улаанбаатар хотын АДХ-ын
Гүйцэтгэх Захиргааны 1969 оны
4-р сарын 10-ны өдрийн 128-р
тогтоолоор батлав.

**УЛААНБААТАР ХОТЫН УЛС, ХОРШООДОЛ, ОЛОН
НИЙТИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ОРОН СУУЦНЫ
БАЙРЫН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ.**

Нэг. Ерөнхий зүйл.

1. Байрын зөвлөл нь, орон сууцны ашиглалт, орчны тохижилт, ариун цэврийг сайжруулан, социалист хууль ёс, олон нийтийн хэв журмыг нарийн чанд сахиулах болон хүүхэд залуучуудыг зөв боловсон хүмүүжүүлэхэд байрныхаа хөдөлмөрчдийг зохион байгуулах зорилготой сайн дурын байгууллага мөн.

2. Байрын зөвлөлийг орон сууцны барилгажилтын онцлогийг харгалзан, орон сууц ашиглалтын байгууллага, ОСГ-ны хороодоос хот, районы гүйцэтгэх захиргаатай зөвшөөрсний үндсэн дээр ЦСТ олон нийтийн бригад, хүүхдийн секцтэйгээр байгуулна.

3. Байрын зөвлөлийг нийтийн орон сууцны подъезд болон ЦСТ олон нийтийн бригад, хүүхдийн секцийн ахлагч нарыг оролцуулан 5-11 хүний бүрэлдүүнтэй оршин суугчдын хурлаас 2 жилийн хугацаагаар сонгон байгуулах тэдгээрийн хурлаас зөвлөлийн даргыг сонгоно.

4. Байрын зөвлөл нь орон сууц ашиглалтын байгууллагын дэрэгдэх төлөөлөгчдийн зөвлөл болон ОСГ-ны хороонд шууд захирагдан тэдгээрийн удирдлага шийдвэрийг биелүүлнэ.

5. Байрын зөвлөлийн дарга нарын хурлаас орон сууц ашиглалтын контор, хэлтсүүдийн дэргэд орон сууц ашиглалтын төлөөлөгчдийн зөвлөлийг 9-15 хүний бүрэлдүүнтэй сонгож байгуулах бөгөөд түүний ахлагч нь орон сууц ашиглалтын контор болон хэлтсийн дарга байна.

6. Байрын зөвлөл нь ажлаа сар, улирал, жилээр төлөвлөн хурлаараа батлаж амиллахын хамт, жилд нэг удаа сонгогчид өөрсө өмнө ташлангаа тавина.

Хоёр. Байрын зөвлөлийн үүрэг.

7. Байрын зөвлөл нь орон байр түүний болкон, цонх, үүд хаалга, коридор, подвал, орчны тохижилтыг байнга цэвэр үзэмтэй бүрэн бүтэн байлгана.

8. Хөдөлмөрчдийн хурал, цуглаан, ухуулга-хурал болон хорооллын тохижилт, нийгмийн цэвэрлэгээнд оршин суугчдыг зохион байгуулж оролцуулна.

9. Оршин суугчдын бүртгэл судамгаар нарийн хяналт, ажил, сургуульгүй дэмий сэлгүүнэгчдийг район АДХ-ын Гүйцэтгэх Захиргаанд шилжүүлэн өгөхийг хамт хүн бүрээс иргэнийхээ үүргийг бүрэн ойлгож биелүүлдэг болгон хүмүүжүүлэх ажлыг зохионо.

10. Орон сууц, хорооллын дотор олон нийтийн хэв журам зөрчих, хэрүүл маргаан гаргах, уул согтууран хүмүүсийн амгалан тайван байдлыг алдагдуулах зэрэг зохисгүй байдал гаргагчдыг тухай бүр илрүүлэн арга хэмжээ авч байна.

11. Байрны дотор хэрэг зөрчил, гал түймэр гарсхаас урьдчилан сэргийлэх аргүүлийн постыг суугчдын дотороос ээлж дараалан "ЭП", гэсэн тэмдэгтэйгээр амралтын өдөр болон оройн цагаар тогтмол гаргаж ажиллуулна.

12. Оршин суугчдаас тавьсан эрэлт хүсэлтийг хүлээн авч орон сууц ашиглалтын контор болон бусад холбогдох байгууллагын өмнө тавьж зохих арга хэмжээг авахуули байна.

Гурав. Байрны зөвлөлийн эрх.

13. Орон байр, түүний тохижилтыг зөв боловсон эзэмшин ашиглах шаардлагыг оршин суугч ба иргэдийн өмнө тавина.

14. Оршин суугчдыг, амралтын өдөр, ажлын бус цагаар ухуулга, хурал цуглаан, эргүү шалгалт нийгмийн цэвэрлэгээ зэрэг амилд татан оролцуулна.

15. Иргэний гэр бүл, тээвэрт, цэргийн бүртгэл, орон сууц нэмэгдэн, радио телефоны хэлс төлөлт, тээврийн ба ангийн хэрэгслэлийн бүртгэл татвар төлөлт зэрэг иргэн нэг бүрийн хууль ёсоор биелүүлэх үүргийг биелэлтэнд байгаа хяналт тавьж ажиллана.

16. Орон сууц ашиглалтын дүрэм, зөвхөл биелүүлэх шийдвэрийн заалтыг зөрчигчид болон үр хүүхдийнхээ хүмүүжилд сул анхаардаг хүмүүсийг зөвлөлийнхөө хурлаар хэлэлцэн олон нийтийн арга хэмжээ авахын хамт, шаардлагатай гэж үзвэл өөрийн санал тодорхойлолтыг орон сууц ашиглалтын контор буюу ОСГ-ны хороо, олон нийтийн шүүх зэрэг зохих байгууллагат тавина.